НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/280/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn | Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Я.Алтанцэцэг<br><br>Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn |
| Улаанбаатар хот 2024 он | Ахлах аудитор: М.Ундармаа<br><br>Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## .ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 450

танай ______________ -ны № ______________ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Г.БАЯРСАЙХАН ТАНАА

### АУДИТЫН ДҮГНЭЛТ

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд Нийслэлийн Замын хөгжлийн газар нь байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлийг 90.5 хувиар хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

000022100

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **179,392,658,150.07** | **178,514,515,347.80** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **9,171,241,352.00** | **8,692,699,558.30** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **9,171,241,352.00** | **8,692,699,558.30** |
| **31210** | **Төгрөг** | **9,171,241,352.00** | **8,692,699,558.30** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 9,171,241,352.00 | 8,692,699,558.30 |
| **33** | **АВЛАГА** | **2,068,443,860.00** | **1,668,443,860.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 508,443,860.00 | 508,443,860.00 |
| **33600** | **Зээлийн авлага** | **1,560,000,000.00** | **1,160,000,000.00** |
| **33620** | **Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага** | **1,560,000,000.00** | **1,160,000,000.00** |
| 33621 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон | 1,560,000,000.00 | 1,160,000,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **8,199,982.50** | **5,754,882.50** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 6,145,100.00 | 3,700,000.00 |
| **34710** | **Урьдчилгаа тооцоо** | **2,054,882.50** | **2,054,882.50** |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 2,054,882.50 | 2,054,882.50 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **113,348,098.57** | **116,192,190.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **1,939,045.50** | **1,414,915.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,939,045.50 | 1,414,915.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **111,409,053.07** | **114,777,275.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,789,630.00 | 11,064,870.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 18,308,033.07 | 18,044,215.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 19,754,500.00 | 11,254,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 16,755,000.00 | 21,325,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 35,194,910.00 | 40,644,910.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,591,700.00 | 1,749,700.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,015,280.00 | 10,694,080.00 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **168,031,424,857.00** | **168,031,424,857.00** |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 168,031,424,857.00 | 168,031,424,857.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,049,758,968.70** | **3,884,131,789.81** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,049,758,968.70** | **3,884,131,789.81** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **967,610,622.05** | **1,824,456,110.16** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 477,243,943.45 | 1,362,977,595.45 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -53,652,145.92 | -89,208,523.68 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 512,610,831.88 | 620,610,831.88 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -348,185,144.38 | -373,453,694.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 1,869,656,249.66 | 1,883,636,149.66 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -1,517,198,258.88 | -1,601,908,703.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 132,621,104.25 | 132,621,104.25 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -106,556,958.01 | -111,543,149.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,780,000.00 | 3,780,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,709,000.00 | -3,055,500.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **2,082,148,346.65** | **2,059,675,679.65** |
| 39301 | Программ хангамж | 1,107,864,100.00 | 1,107,864,100.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,059,147,738.83 | -1,081,620,405.83 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,033,431,985.48 | 2,033,431,985.48 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **182,442,417,118.77** | **182,398,647,137.61** |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **11,239,685,212.00** | **10,361,143,418.30** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **508,443,860.00** | **508,443,860.00** |
| **41300** | **Өглөг** | **508,443,860.00** | **508,443,860.00** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 508,443,860.00 | 508,443,860.00 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **10,731,241,352.00** | **9,852,699,558.30** |
| **42200** | **Урт хугацаат зээл** | **10,731,241,352.00** | **9,852,699,558.30** |
| **42210** | **Төгрөг** | **9,171,241,352.00** | **8,692,699,558.30** |
| 42216 | Төслийн зээл | 1,560,000,000.00 | 1,160,000,000.00 |
| 42217 | Санхүүгийн бусад байгууллага | 9,171,241,352.00 | 8,692,699,558.30 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **171,202,731,906.77** | **172,037,503,719.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **171,202,731,906.77** | **172,037,503,719.31** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,868,476,531.69 | 1,868,476,531.69 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,868,476,531.69 | 1,868,476,531.69 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **169,117,074,631.77** | **169,951,846,444.31** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 167,472,786,235.36 | 169,117,074,631.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,644,288,396.41 | 834,771,812.54 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 217,180,743.31 | 217,180,743.31 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **182,442,417,118.77** | **182,398,647,137.61** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **123,612,658,426.24** | **185,892,341,911.20** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,479,286,906.38** | **4,125,946,065.20** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,479,286,906.38** | **4,125,946,065.20** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **642,992,159.00** | **3,130,142,413.20** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 642,259,701.00 | 3,130,142,413.20 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 732,458.00 | 0 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,782,932,754.43 | 993,733,652.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 53,361,992.95 | 2,070,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **121,133,371,519.86** | **181,766,395,846.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **517,694,999.94** | **651,600,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 517,694,999.94 | 651,600,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,230,450,700.00** | **1,078,326,879.90** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,230,450,700.00 | 1,078,326,879.90 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **119,385,225,819.92** | **180,036,468,966.10** |
| 133003 | Хөрөнгийн | 119,385,225,819.92 | 180,036,468,966.10 |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **121,968,370,029.83** | **5,033,763,449.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **121,968,370,029.83** | **5,033,763,449.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **120,484,200,321.64** | **3,456,289,211.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,298,236,571.10** | **1,907,710,548.96** |
| 210101 | Үндсэн цалин | 889,605,965.20 | 1,182,050,223.59 |
| 210102 | Нэмэгдэл | 214,052,075.70 | 318,875,820.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 103,402,504.20 | 202,339,654.93 |
| 210104 | Урамшуулал | 91,176,026.00 | 204,444,850.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **164,674,042.30** | **241,288,608.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,147,403.24 | 164,839,944.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,268,974.96 | 19,392,934.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,400,139.76 | 15,267,947.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,531,082.62 | 3,779,114.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,326,441.72 | 38,008,667.81 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **24,411,868.61** | **55,248,149.86** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,627,035.67 | 42,692,056.36 |
| 210302 | Түлш, халаалт | 2,963,632.94 | 6,234,893.50 |
| 210304 | Байрны түрээс | 5,821,200.00 | 6,321,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **88,561,145.31** | **133,760,621.26** |
| 210401 | Бичиг хэрэг | 27,349,438.00 | 37,825,490.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 52,167,000.00 | 80,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,756,707.31 | 10,190,793.19 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0 | 5,537,938.07 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 288,000.00 | 0 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 0 | 206,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **118,162,910,691.91** | **47,724,210.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,595,200.00 | 4,709,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,092,500.00 | 0 |
| 210604 | Урсгал засвар | 118,154,222,991.91 | 43,014,410.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **551,954,432.94** | **891,222,941.50** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 528,000,379.94 | 872,031,662.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,564,248.00 | 10,631,843.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,193,184.00 | 844,446.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 240,000.00 | 286,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,870,000.00 | 4,579,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,771,271.00 | 2,325,860.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 7,315,350.00 | 524,130.50 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **193,451,569.47** | **179,334,130.89** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,240,336.00 | 5,453,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,720,000.00 | 540,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 186,491,233.47 | 173,340,730.89 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,484,169,708.19** | **1,577,474,238.20** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **65,972,950.00** | **46,521,825.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 53,256,952.00 | 38,500,825.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,715,998.00 | 8,021,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,418,196,758.19** | **1,530,952,413.20** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,418,196,758.19 | 1,530,142,413.20 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 810,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,644,288,396.41** | **180,858,578,461.64** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0** | **180,023,806,649.10** |
| 225012 | Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал | 0 | 180,023,806,649.10 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **1,644,288,396.41** | **834,771,812.54** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **125,466,833,111.87** | **178,521,198,366.20** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,148,456,971.01** | **7,510,334,107.65** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **6,148,456,971.01** | **7,510,334,107.65** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **6,148,456,971.01** | **7,510,334,107.65** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,937,831,729.01 | 3,130,142,413.20 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,210,625,242.00 | 4,380,191,694.45 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **119,318,376,140.86** | **171,010,864,258.55** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **517,694,999.94** | **651,600,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 517,694,999.94 | 651,600,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,230,450,700.00** | **1,078,326,879.90** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,230,450,700.00 | 1,078,326,879.90 |

| | | | |
|---|---|---|---|
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **117,570,230,440.92** | **169,280,937,378.65** |
| 133003 | Хөрөнгийн | 117,570,230,440.92 | 169,280,937,378.65 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,670,037,428.95** | **4,846,089,393.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,670,037,428.95** | **4,846,089,393.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,185,843,718.76** | **3,268,915,154.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,300,422,951.60** | **1,907,710,548.96** |
| 210101 | Үндсэн цалин | 903,587,452.90 | 1,182,050,223.59 |
| 210102 | Нэмэгдэл | 193,978,974.00 | 318,875,820.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 111,680,498.70 | 202,339,654.93 |
| 210104 | Урамшуулал | 91,176,026.00 | 204,444,850.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **164,726,542.30** | **241,288,608.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,147,403.24 | 164,839,944.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,321,474.96 | 19,392,934.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,400,139.76 | 15,267,947.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,531,082.62 | 3,779,114.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,326,441.72 | 38,008,667.81 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **24,367,043.61** | **55,248,149.86** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,627,035.67 | 42,692,056.36 |
| 210302 | Түлш, халаалт | 2,918,807.94 | 6,234,893.50 |
| 210304 | Байрны түрээс | 5,821,200.00 | 6,321,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **70,051,717.31** | **135,688,923.19** |
| 210401 | Бичиг хэрэг | 20,093,010.00 | 37,850,130.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 41,957,000.00 | 82,665,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,001,707.31 | 10,190,793.19 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0 | 4,983,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | **0** | **7,050,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0 | 7,050,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **70,849,725.00** | **38,038,410.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,552,600.00 | 6,009,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,377,500.00 | 2,207,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 53,919,625.00 | 29,821,610.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **548,183,202.94** | **877,164,614.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 525,836,499.94 | 858,497,465.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,564,248.00 | 10,631,843.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,193,184.00 | 844,446.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 240,000.00 | 286,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,870,000.00 | 4,579,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,771,271.00 | 2,325,860.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 5,708,000.00 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,242,536.00** | **6,725,900.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,242,536.00 | 6,185,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0 | 540,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,484,193,710.19** | **1,577,174,238.20** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **65,996,952.00** | **46,221,825.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 53,256,952.00 | 38,500,825.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,740,000.00 | 7,721,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,418,196,758.19** | **1,530,952,413.20** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,418,196,758.19 | 1,530,142,413.20 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 810,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **121,796,795,682.92** | **173,675,108,973.10** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **119,705,138,040.52** | **174,153,650,766.80** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **119,705,138,040.52** | **174,153,650,766.80** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **119,705,138,040.52** | **174,153,650,766.80** |
| 220001 | Барилга байгууламж | 107,630,403,175.92 | 133,241,181,155.60 |
| 221001 | Их засвар | 0 | 12,662,317.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 12,058,794,864.60 | 40,885,827,394.20 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 15,940,000.00 | 13,979,900.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-119,705,138,040.52** | **-174,153,650,766.80** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **2,091,657,642.40** | **-478,541,793.70** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 7,079,583,709.60 | 9,171,241,352.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 9,171,241,352.00 | 8,692,699,558.30 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,868,476,531.69 | 217,180,743.31 | 167,472,786,235.36 | 169,558,443,510.36 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,868,476,531.69 | 217,180,743.31 | 167,472,786,235.36 | 169,558,443,510.36 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,644,288,396.41 | 1,644,288,396.41 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,868,476,531.69 | 217,180,743.31 | 169,117,074,631.77 | 171,202,731,906.77 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,868,476,531.69 | 217,180,743.31 | 169,117,074,631.77 | 171,202,731,906.77 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,868,476,531.69 | 217,180,743.31 | 169,117,074,631.77 | 171,202,731,906.77 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 834,771,812.54 | 834,771,812.54 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,868,476,531.69 | 217,180,743.31 | 169,951,846,444.31 | 172,037,503,719.31 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,462,944,400.00** | **2,678,326,879.90** | **-784,617,520.10** | 77.3% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,462,944,400.00** | **2,678,326,879.90** | **-784,617,520.10** | 77.3% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,397,241,200.00** | **2,632,105,054.90** | **-765,136,145.10** | 77.5% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,311,769,500.00** | **1,907,710,548.96** | **-404,058,951.04** | 82.5% |
| 210101 | Үндсэн цалин | 1,317,016,800.00 | 1,182,050,223.59 | **-134,966,576.41** | 89.8% |
| 210102 | Нэмэгдэл | 550,880,600.00 | 318,875,820.24 | **-232,004,779.76** | 57.9% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 229,900,000.00 | 202,339,654.93 | **-27,560,345.07** | 88.0% |
| 210104 | Урамшуулал | 213,972,100.00 | 204,444,850.20 | **-9,527,249.80** | 95.5% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **288,971,200.00** | **241,288,608.89** | **-47,682,591.11** | 83.5% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 196,500,400.00 | 164,839,944.56 | **-31,660,455.44** | 83.9% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,117,700.00 | 19,392,934.49 | **-3,724,765.51** | 83.9% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 18,494,100.00 | 15,267,947.57 | **-3,226,152.43** | 82.6% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,623,600.00 | 3,779,114.46 | **-844,485.54** | 81.7% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 46,235,400.00 | 38,008,667.81 | **-8,226,732.19** | 82.2% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **72,187,000.00** | **55,248,149.86** | **-16,938,850.14** | 76.5% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 50,944,600.00 | 42,692,056.36 | **-8,252,543.64** | 83.8% |
| 210302 | Түлш, халаалт | 9,600,000.00 | 6,234,893.50 | **-3,365,106.50** | 64.9% |
| 210304 | Байрны түрээс | 11,642,400.00 | 6,321,200.00 | **-5,321,200.00** | 54.3% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **137,249,300.00** | **135,688,923.19** | **-1,560,376.81** | 98.9% |
| 210401 | Бичиг хэрэг | 37,850,500.00 | 37,850,130.00 | **-370.00** | 100.0% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 83,132,000.00 | 82,665,000.00 | **-467,000.00** | 99.4% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,266,800.00 | 10,190,793.19 | **-1,076,006.81** | 90.4% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,000,000.00 | 4,983,000.00 | **-17,000.00** | 99.7% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **7,055,000.00** | **7,050,000.00** | **-5,000.00** | 99.9% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,055,000.00 | 7,050,000.00 | **-5,000.00** | 99.9% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **52,215,000.00** | **52,018,310.00** | **-196,690.00** | 99.6% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,000,000.00 | 19,989,200.00 | **-10,800.00** | 99.9% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,215,000.00 | 2,207,500.00 | **-7,500.00** | 99.7% |
| 210604 | Урсгал засвар | 30,000,000.00 | 29,821,610.00 | **-178,390.00** | 99.4% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **520,982,200.00** | **226,374,614.00** | **-294,607,586.00** | 43.5% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 488,115,400.00 | 207,707,465.00 | **-280,407,935.00** | 42.6% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 11,155,100.00 | 10,631,843.00 | **-523,257.00** | 95.3% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,835,800.00 | 844,446.00 | **-991,354.00** | 46.0% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 600,000.00 | 286,000.00 | **-314,000.00** | 47.7% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,000,000.00 | 4,579,000.00 | **-421,000.00** | 91.6% |
| 210807 | Газрын төлбөр | 2,325,900.00 | 2,325,860.00 | **-40.00** | 100.0% |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 11,950,000.00 | 0 | **-11,950,000.00** | 0.0% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,812,000.00** | **6,725,900.00** | **-86,100.00** | 98.7% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,272,000.00 | 6,185,900.00 | **-86,100.00** | 98.6% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 540,000.00 | 540,000.00 | **0.00** | 100.0% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **65,703,200.00** | **46,221,825.00** | **-19,481,375.00** | 70.3% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **65,703,200.00** | **46,221,825.00** | **-19,481,375.00** | 70.3% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 54,825,700.00 | 38,500,825.00 | **-16,324,875.00** | 70.2% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,877,500.00 | 7,721,000.00 | **-3,156,500.00** | 71.0% |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,462,944,400.00** | **4,208,469,293.10** | **745,524,893.10** | 121.5% |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,862,944,400.00** | **1,078,326,879.90** | **-784,617,520.10** | 57.9% |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,862,944,400.00 | 1,078,326,879.90 | **-784,617,520.10** | 57.9% |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН** | **1,600,000,000.00** | **3,130,142,413.20** | **1,530,142,413.20** | 195.6% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | | | |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,600,000,000.00 | 3,130,142,413.20 | **1,530,142,413.20** | 195.6% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **651,600,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **651,600,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 650,790,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 650,790,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 650,790,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 810,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **810,000.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 810,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 651,600,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 651,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 651,600,000.00 |

# 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,860,194.9 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулав.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг 8,692,699.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайланд урьдчилгаа дансны үлдэгдлийг 1,162,445.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардлыг 2,445.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 1,795.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг 810.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга,

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 *“Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх”* болон санхүүгийн тайлангийн *тохиолдсон байх*, *толилуулга* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 458,551.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс сахилга хариуцлагатай холбоотой 1, 452,797.0 мянган төгрөгийн зөрчилд 1, нийт 2 албан шаардлага хүргүүлж, 5,754.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Албан шаардлага

3.1.1 Захиалагчаас гэрээг дүгнэж ажиллаагүйгээс үүссэн 2015-2018 оны 30 ажлын барьцааны үлдэгдэл 452,797.0 мянган төгрөгийн өр, төлбөрийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *“үнэн зөв байх”*, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 *“Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”,* 20 дугаар зүйлийн 20.2.6 *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлан мэдээг ирүүлээгүй 7 хоногоор хоцроосон, тайлант жилийн санхүүгийн баримтыг үдэж архивлаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 "*төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх*", Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 *"төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах",* 16.1.4 *“төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх”* заалтуудыг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Зардлын данстай холбоотой асуудал:***

<u>*Илрүүлэлт 1:*</u> Урьдчилж гарсан зардал 3,700.0 мянга, цалингийн урьдчилгаа 2,054.9 мянга, нийт 5,754.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", 16 дугаар зүйлийн 16.5.2 *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 20.2.5 *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах* " 20.2.6 *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"*, заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн урьдчилгаа болон урьдчилж гарсан зардлыг барагдуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

*Илрүүлэлт 2:* Тайлант онд нэр бүхий 5 ажилчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, нэмэгдэл цалин олгоогүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах";* Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 *"Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно",* 110 дугаар зүйлийн 110.2 *"Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно"*

*Өгсөн зөвлөмж*: Ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, амруулаагүй тохиолдолд цалинг нэмэгдүүлэн олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх

***Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:***

*Илрүүлэлт 3:* Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 827 ширхэг (*2,747,062.7 мянган төгрөгийн*) хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 *"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72, 73 дугаар зүйлийн холбогдох заалт"*, Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 *"Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1 *"Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*"

*Өгсөн зөвлөмж*: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдийг ангилан дахин үнэлж бүртгэх асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлэх арга хэмжээ авах, хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайланд төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг дутуу тайлагнасан. | 1 | 8,692,699.6 | | | 1 | 8,692,699.6 | 1 | 8,692,699.6 | | | | |
| Санхүүгийн байдлын тайланд урьдчилгаа дансны үлдэгдлийг илүү тайлагнасан. | 1 | 1,162,445.1 | | | 1 | 1,162,445.1 | 1 | 1,162,445.1 | | | | |
| Санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардлыг илүү тайлагнасан. | 1 | 2,445.1 | | | 1 | 2,445.1 | 1 | 2,445.1 | | | | |
| Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг илүү тайлагнасан. | 1 | 1,795.1 | | | 1 | 1,795.1 | 1 | 1,795.1 | | | | |
| Нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг дутуу тайлагнасан. | 1 | 810.0 | | | 1 | 810.0 | 1 | 810.0 | | | | |
| **Дүн** | **5** | **9,860,194.9** | | | **5** | **9,860,194.9** | **5** | **9,860,194.9** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өмнөх онуудаас дамжсан 2015-2018 оны 30 ажлын гүйцэтгэл хангагдаагүй барьцааг татан төвлөрүүлээгүй. | 1 | 452,797.0 | | | 1 | 452,797.0 | | | | | | |
| Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тайлан мэдээг ирүүлээгүй хоцроосон, тайлант жилийн санхүүгийн баримт материалыг үдэж архивлаагүй. | 1 | - | | | | | | | 1 | 2 | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал 3,700.0 мянга, цалингийн урьдчилгаа 2,054.9 мянган төгрөгийг тайлант онд барагдуулаагүй. | 1 | 5,754.9 | | | | | 1 | 5,754.88 | | | | |
| Тайлант онд нэр бүхий 5 ажилчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, нэмэгдэл цалин олгоогүй. | 1 | - | | | | | 1 | 0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 827 ширхэг 2,747,062.7 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **5** | **458,551.9** | | | **1** | **452,797.0** | **3** | **5,754.9** | **1** | **2** | **0** | **0** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Худалдан авалт хийхдээ төсөвт өртгийг хэд хэд хуваан шууд худалдан авалт хийсэн, гэрээ байгуулаагүй байна. | 1 | 36,109.6 | | | | | 1 | 36,109.6 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Их хэмжээгээр шатахуун нөөцөлсөн. | 1 | 21,325.0 | | | | | 1 | 21,325.0 |
| **Дүн** | **2** | **57,434.6** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **57,434.6** |